



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 149

Улаанбаатар хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**


Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2 дах заалт, Монгол улсын Их хурлын 2014 оны “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого батлах тухай” 57 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Эмийн чанарыг хангах чиглэлээр оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Эмийн чанарыг хангах чиглэлээр оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулах ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эмийн чанарыг хангах чиглэлээр оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөөг 2015 оны 2 дугаар улиралд багтаан боловсруулж Хүний эмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, зохих журмын дагуу батлуулахыг ажлын хэсгийн ахлагч (М.Уранчимэг)-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Г.Ганчимэг)-т үүрэг болгосугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 04 сарын 17 өдрийн  
14.9 дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт

### Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

- Ажлын хэсгийн ахлагч: М.Уранчимэг, ЭМБХЗГ-ын Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн дарга
- Нарийн бичгийн дарга: Д.Уранчимэг, ЭМБХЗГ-ын Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн мэргэжилтэн
- Гишүүд:
- П.Цэцгээ, СБТГ-ын Эм, эмнэлгийн хэрэгслийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
  - Ш.Энхтуяа, МХЕГ-ын эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч (зөвшилцсөнөөр)
  - Д.Өлзийдулам, МХЕГ-ын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн Эм, био бэлдмэлийн лабораторийн менежер (зөвшилцсөнөөр)
  - О.Уранчимэг, ХСҮТ-ийн Эмзүйн албаны дарга
  - С.Пүрэвсүрэн, АХБ-ны ЭМХХ-4 төслийн үндэсний зөвлөх
  - Т.Цацрал, АХБ-ны ЭМХХ-4 төслийн үндэсний зөвлөх
  - Б.Таванжин, Айвико эмийн үйлдвэрийн үйлдвэрлэл эрхэлсэн захирал (зөвшилцсөнөөр)
  - Б.Мөнхдэлгэр, Омбол ХХК-ний менежер (зөвшилцсөнөөр)
  - Г.Оюунцэцэг, Магофарм эмийн сангийн эрхлэгч (зөвшилцсөнөөр)
  - Ж.Рэнцэнамгалан, МЭЗБН Эм холбооны ерөнхийлөгч (зөвшилцсөнөөр)
  - Д.Цэндээхүү, Эм хангамжийн байгууллагуудын холбооны тэргүүн (зөвшилцсөнөөр)
  - Б.Машбадрах, Монголын НЭМ-ийн мэргэжилтнүүдийн нийгэмлэгийн гүйцэтгэх захирал (зөвшилцсөнөөр)

Эрүүл мэнд, спортын сайдын  
2015 оны 04 сарын 17 өдрийн  
1.4 дугаар тушаалын 2 дугаар  
хавсралт

**ЭМИЙН ЧАНАРЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ОРОЛЦОГЧ  
ТАЛУУДТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ  
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

**Үндэслэл:**

Монгол улсын Их хурлын 2014 оны “Төрөөс эмийн талаар баримтлах бодлого батлах тухай” 57 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх

**Зорилго:**

Эмийн чанарыг хангах чиглэлээр оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулж батлуулах

**Үйл ажиллагааны чиглэл:**

- Эмийн чанарыг хангах чиглэлээр оролцогч талуудтай хамтран ажиллах төлөвлөгөөний төслийг Төрөөс эмийн талаар баримтлах бодлого болон эмийн чанартай холбоотой бусад эрх зүйн баримт бичгийг үндэслэн боловсруулах
- Эмийн чанарыг хангах чиглэлээр эм үйлдвэрлэх, ханган нийлүүлэх, хадгалах, түгээх, чанарт хяналт тавих үйл ажиллагаанд оролцогч талуудын хийх үйл ажиллагааг төлөвлөгөөнд бүрэн тусгах
- Төлөвлөгөөний төсөлд эм хангамжийн байгууллага болон эм зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн ба төрийн бус байгууллагаас санал авч тусгах
- Төлөвлөгөөний төслийг Хүний эмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх
- Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулах

**Хэрэгжүүлэх байгууллага:**

ЭМЯ-ны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтэс

**Гүйцэтгэх хугацаа:**

2015 оны 2-р улирал

**Хүрэх үр дүн:**

- Эмийн чанарыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг бүрэн тусгасан төлөвлөгөө батлагдан гарсан байна.
- Эмийн чанарт тавих хяналт сайжирч, хэрэглэгчдийг чанартай эмээр хангах нөхцөл бүрдэнэ.
- Эмийн үйлдвэр, эм ханган нийлүүлэх байгууллага нь өөрийн бүтээгдэхүүний чанарын баталгааг хариуцах, бүртгэлийн дараах аюулгүй байдлын тандалт судалгаа хийх үүрэг хүлээх, үр дүнг мэдээлэх тогтолцоо бүрдэнэ.